



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 63

Эрдэнэт

“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар
баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн
дэд хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2015 ны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 5.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”-ийг нэгдүгээр, 2017-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах төсөв, хөрөнгийг тухайн жилийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн I улиралд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

00100051